



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/23

Арвайхээр сум

**Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл сунгах,
нэршил өөрчлөх тухай**

Боловсролын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны “Ерөнхий боловсролын зарим сургуулийн талаар авах арга хэмжээний тухай” тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газрын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн санал, дүгнэлтийн дагуу ерөнхий боловсролын лаборатори Мэргэд сургуулийн нэршлийг Арвайхээр сумын ерөнхий боловсролын Мэргэд сургууль болгон өөрчилсүгэй.

2.Тус сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж, нэршил өөрчлөгдсөнтэй холбогдуулан сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 12 жилийн хугацаатай сунгасугай.

3.Дээрх нэршил өөрчлөгдсөн ерөнхий боловсролын сургуулийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулан, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газар (Г.Пүрэвдорж)-т даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0045